



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/52


Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/ 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сагсан бөмбөгийн улсын аварга шалгаруулах 21 аймгийн дундах “Үндэсний Цом – 2016” сагсан бөмбөгийн лигт оролцож буй “Эрдэнэт-Икон” багийн тамирчин БНАСАУ-ын Үндэсний шигшээ багийн ахлагч Син Кум Бёл, дасгалжуулагч Ан Ён Бин нарын онгоцны тиз, урамшуулал болон цанын спортын улсын аваргын тэмцээнд явж буй Орхон аймгийн өсвөрийн шигшээ багийн зардлыг хавсралтаар баталсугай.

2. Уг зардалд шаардагдах 4486000 /Дөрвөн сая дөрвөн зуун наян зургаан мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын “Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээ”-ний жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ

Аймгийн Засаг даргын 2017 оны  
...дугаар сарын ...-ны өдрийн ...дугаар  
захирамжийн нэгдүгээр хавсралт



ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Хэрэгжүүлэх ажил, зардлын нэр төрөл	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Бүгд
1	Эрдэнэт Икон зардал	4'000'000	4'000'000	4'000'000
2	Цанын өсвөрийн шигшээ зардал	486'000	486'000	486'000
3	Нийт			4'486'000